

ХҮЧИЛТӨРӨГЧ ӨТГӨРҮҮЛЭГЧИЙН АШИГЛАЛТ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЗААВАР

Монгол нэр: **Хүчилтөрөгч өтгөрүүлэгч;**

Англи нэр: **Oxygen concentrator**

Олон улсын код: **UMDNS 12873**

Хүчилтөрөгч өтгөрүүлэгч нь агаарын найрлага дахь хүчилтөрөгчийн агууламжийг нэмэгдүүлэх буюу агаараас азотыг шүүж, ялгаж авсан хүчилтөрөгчийн 90%-иас дээш агууламжтай хийг чийгшүүлэн өвчтөнд өгөх хамрын гуурс болон маскаар өгөх зориулалттай аппарат юм. Хүчилтөрөгч өтгөрүүлэгчийг суурин эсвэл зөөврийн гэж ангилах бөгөөд 3-аас 8 л/мин хүртэлх эзлэхүүнээр хийг дамжуулах хүчин чадалтай байдаг.

Ажиллуулах зааварчилгаа

1. Чийгшүүлэгч саванд нэрмэл ус хийж, аппаратад холбоно.
2. Хамрын гуурс эсвэл маскийг чийгшүүлэгч саванд холбоно.
3. Аппаратыг цахилгаан тэжээлд холбоно.
4. Асаах /унтраах/ товчлуурыг **“On”** байрлалд тавина.
5. Хүчилтөрөгчийн урсгалыг эмчийн зааврын дагуу тохируулна.
6. Хамрын гуурс эсвэл маскийг өвчтөнд холбоно.
7. Асаах /унтраах/ товчлуурыг **“Off”** байрлалд тавина.
8. Ашиглаж дууссаны дараа аппаратыг цахилгаан тэжээлээс салгана.
9. Чийгшүүлэгч савны усыг асгаж, цэвэрлэн дараагийн эмчилгээнд бэлэн болгоно.

Аюулгүй ажиллагааны зааварчилгаа

- Хүчилтөрөгч өтгөрүүлэгчид шаардагдах агаарын урсгалыг чөлөөтэй нэвтрүүлэхийн тулд хана, эд хогшлоос 50 см-ээс багагүй зайд байрлуулна.
- Чийгшүүлэгч савны усны түвшингийн хязгаараас их ус хийж болохгүй.
- Ногоон гэрэл - хэвийн ажиллагааг заах ба хүчилтөрөгчийн өтгөрүүлэг 85%-иас их байгааг заана.
- Шар гэрэл - хүчилтөрөгчийн өтгөрүүлэг 70-ээс 84%-ийн хооронд хэлбэлзэж байгааг заана.
- Улаан гэрэл - хүчилтөрөгчийн концентрац 70%- иас бага хэмжээнд байгааг заах ба энэ тохиолдолд үргэлжилсэн дуут дохио дуугарч автоматаар ажиллагаа зогсдог. Асаах /унтраах/ товчлуурыг **“Off”** байрлалд тавиж, цахилгаан тэжээлээс салгана.
- Хүчилтөрөгчийн хийн шатамхай хий тул аппаратын ойр орчимд ил гал гаргах, тостой гараар хүрэхийг хориглоно.

Шалгах хуудас

Өдөр тутам	
Цэвэрлэгээ	✓ Чийгтэй алчуураар тоос болон бохирдлыг арчаад дараа нь хаттал нь арчина.
Харж шалгах	✓ Бүх дагалдах хэрэгсэл, холбогч гуурс зөв залгагдсан эсэхийг шалгана.
Үйл ажиллагааг шалгах	✓ Хэрэглэхээсээ өмнө хүчилтөрөгчийн урсгалыг шалгана.
7 хоног бүр	
Цэвэрлэгээ	✓ Шүүлтүүрийг халуун усаар угааж хатаана. Хэрвээ гэмтсэн байвал солино. ✓ Чийгшүүлэгч савыг цэвэрлэж хатаана.
Харж шалгах	✓ Чийгшүүлэгч саван дотор чулуужсан давхарга үүссэн бол солино. ✓ Тэжээлийн залгуур шалбарсан эсвэл гэмтсэн эсэхийг шалгаж, солино.
Үйл ажиллагааг шалгах	✓ Аппаратыг 2 минут ажиллуулан ямар нэг алдаа зааж байгаа эсэхийг шалгана. ✓ Урсгал хэмжигч ашиглан урсгалын олон сонголтыг шалгана.
6 сар тутам	
Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер шалгалт хийнэ.	
1 жил тутам	
Мэргэжлийн байгууллагаар шалгалт тохируулга хийлгэнэ.	

Түгээмэл гардаг алдаа, гэмтэл

Алдаа	Шалтгаан	Засварлах
Аппарат ажиллахгүй, хүчдэлийн алдааны дуут дохио өгөх	Залгуурт хүчдэл ирээгүй байх Концентратор тохируулагдаагүй байх Цахилгаан утас гэмтсэн байх	Унтраалга ассан эсэхээ шалга. Гал хамгаалагч шатсан байвал тохирох гал хамгаалагч сольж хийнэ. Мультиметр ашиглан шугамын хүчдэл байгаа эсэхийг шалгана. Хэрэв хүчдэл байхгүй бол цахилгаанчин дуудна. Дахин тохируулах /RESET/ товчлуур байвал түүнийг дарна. Цахилгаан утсыг солино. Шаардлагатай бол цахилгаанчин дуудна.
Аппарат ажиллахгүй, хүчдэлийн алдааны дуу гарахгүй байх	Дуут дохионы зай дууссан.	Зайг солиод дахин шалгана.
Хүчилтөрөгчийн урсгал байхгүй байх	Урсгал байхгүй байх	Гуурсыг усан доор байрлуулаад бөмбөлөг үүсч байгаа эсэхийг шалгана. Бөмбөлөг гарч байвал хэвийн байгааг илтгэнэ.

	Гуурснууд зөв холбоогүй байх Хүчилтөрөгчийн гуурсыг ус эсвэл ямар нэг зүйл бөглөсөн байх Урсгал метр эсвэл чийгшүүлэгч сав бөглөрсөн байх	Гуурс болон холбогчийг зөв холбосон эсэхийг шалгана. Их даралттай усаар гуурсыг зайлж буцаж байрлуулахаас өмнө сайтар хатаана. Урсгал метр, савыг сольж тавих эсвэл эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер дуудна.
Температурын гэрэл болон бага хүчилтөрөгчтэй байна гэсэн дохио өгөх	Аппарат хэт их халсан эсвэл гаралтад саад учирсан байх	Хөшиг, бүтээлэг, хана зэрэг саад учруулж буй зүйлсээс аппаратыг холдуулна. Шүүлтүүрийг цэвэрлэнэ. Аппаратыг унтраагаад 30 минут болсны дараа дахин асаана. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер дуудна.
Цахилгааны гэмтэл эсвэл гал хамгаалагч шатсан.	Цахилгааны утас гэмтсэн байх	Цахилгаанчин дуудна.